

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Багахангай дүүргийн Илч-Орд ОНӨААТҮГ-ын
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/204/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Нийслэл дэх төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г. Нандинжаргал Утас: 7000-7734 Цахим хаяг: nandiniargalg@audit.gov.mn</p> <p>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: С.Гантөгс Утас: 325093 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn</p> <p>Гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлт хөхийн тэнцвэр Аудит ХХК-ийн захирал: Д.Баатарсайхан Утас: 9909-9119 Цахим хаяг: gerelthuhaudit@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	Error! Bookmark not defined.
3.1 Компани /ТӨҮГ/, түүний үйл ажиллагаа	Error! Bookmark not defined.
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	Error! Bookmark not defined.
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	Error! Bookmark not defined.
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	Error! Bookmark not defined.
3.5. Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл.....	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал	Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	Error! Bookmark not defined.
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	9

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НИТХ	Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
НТАГ	Нийслэл дэх төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.03.13 № 105
танай _____-ны № _____-т

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ИЛЧ-ОРД
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Д.ГАНТУЛГА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багахангай дүүргийн Илч Орд ОНӨААТҮГ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг байдлын үүднээс Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд 2800-3200 ккал илчлэгтэй нийт 4,561 тн нүүрсийг 309.1 сая төгрөгөөр худалдан авч 534 айл өрх, 36 аж ахуйн нэгжийг халаалт болон хэрэглээний халуун усаар ханган ажилласан байна.

Аудитын гол асуудал

Багахангай дүүргийн Засаг даргын захирамжаар тус байгууллагын эдийн засгийн зорилтот түвшинг нийт орлогыг 2,985.2 сая төгрөг, нийт зардлыг 3,342.4 сая төгрөг, 357.2 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталснаас гүйцэтгэлээр 2,816.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,877.2 сая төгрөгийн зардал гаргаж 60.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 88 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 94.5 хувийн хэрэгжилттэй гүйцэтгэсэн гэж тайлагнасан байна.

С/Хангалуун /Оюу-Бичиг хэргийн хэлтэс/ 1426050871

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	7,435,474.17	23,165,201.07
Дансны авлага	50,411,210.32	32,616,911.38
Татвар, НДШ – ийн авлага	1,152,681.08	1,152,681.08
Бусад авлага	487,409.47	342,144.68
Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	646,657.0	4,857,108.38
Бараа материал	86,871,067.21	100,647,767.86
Эргэлтийн хөрөнгийн дүн	147,004,499.25	162,781,814.45
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	2,893,884,304.03	2,803,842,750.06
Биет бус хөрөнгө	213,579,600.0	213,579,600.00
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,107,463,904.03	3,016,882,350.06
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,254,468,403.28	3,179,664,164.51
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр	-	54,319.0
Дансны өглөг	183,520.0	9,767,014.01
Цалингийн өглөг		-
Татварын өр	26,908,139.25	18,763,352.36
Урьдчилж орсон орлого	1,398,983.00	3,166,006.74
Хойшлогдсон орлого	17,180,880.0	-
Богино хугацаат өр төлбөрийн дүн	45,671,522.25	31,750,692.11
Хойшлогдсон орлого	119,911,162.10	119,911,162.10
Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	119,911,162.10	119,911,162.10
Өр төлбөрийн нийт дүн	165,582,684.35	151,661,854.21
Эздийн өмч		
Өмч:-төрийн	60,738,200.0	60,738,200.00
- хувийн	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	862,331,962.30	862,331,962.30
Эздийн өмчийн бусад хэсэг	210,609,600.0	210,609,600.00
Хуримтлагдсан ашиг, алдагдал	1,955,205,956.63	1,894,322,548.00
Тайлант үеийн ашиг, алдагдал		(60,883,408.63)
Эздийн өмчийн дүн	3,088,885,718.93	3,028,002,310.30
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,254,468,403.28	3,179,664,164.51

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үйл ажиллагааны орлого	1,839,620,065.02	2,771,477,354.16
	Нийт ашиг (алдагдал)	44,560,654.23	476,038,699.90
3	Хүүгийн орлого	442,525.31	871,191.18
6	Бусад орлого	34,920,868.0	43,989,032.71
8	Ерөнхий ба удирдлагын зардал	324,844,822.32	522,456,812.42
10	Бусад зардал	28,761,450.0	59,325,520.00

	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(273,682,224.78)	(60,883,408.63)
19	Орлогын татварын зардал	44,252.53	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(273,726,477.31)	(60,883,408.63)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(273,726,477.31)	(60,883,408.63)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар

/ төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,042,729,086.08	3,118,394,569.24
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	634,097,217.50	667,718,182.28
1.1.6	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	454,245.25	978,539.49
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	32,068.0	1,289,647.00
	Татаас санхүүжилтийн орлого	1,367,206,600.0	2,398,791,800.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	40,938,955.33	49,616,400.47
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,062,725,018.60	3,102,664,842.34
1.2.1	Ажиллагчдад төлсөн	860,513,469.64	1,335,400,702.01
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	233,299,745.12	359,542,569.32
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	230,671,650.30	490,326,300.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	238,512,899.16	273,519,691.92
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	355,564,742.0	390,731,660.59
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	124,391,293.96	220,491,084.50
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	395,685.0	454,734.00
1.2.10	Бусад мөнгөн зарлага	19,375,533.42	32,198,100.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(19,995,932.52)	15,729,726.90
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	14,405,600.00	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	14,405,600.0	
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(14,405,600.0)	
4	Валютын ханшийн зөрүү	-	-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(34,401,532.52)	15,729,726.90
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	41,837,006.69	7,435,474.17
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,435,474.17	23,165,201.07

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	60,738,200.00	795,767,499.30	2,228,932,433.94	3,296,047,733.24
3	Залруулсан үлдэгдэл	60,738,200.00	795,767,499.30	2,228,932,433.94	3,296,047,733.24
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)	-	-	(273,726,477.31)	(273,726,477.31)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		66,564,463.0		66,564,463.00
9	2024 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	60,738,200.00	862,331,962.30	1,955,205,956.63	3,088,885.718.93
11	Залруулсан үлдэгдэл	60,738,200.00	862,331,962.30	1,955,205,956.63	3,088,885.718.93
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(60,883,408.63)	(60,883,408.63)
17	2025 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	60,738,200.00	862,331,962.30	1,894,322,548.0	3,028,002,310.30

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт		ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Биелэлт хувь	Зөрүү
1. Нийт орлого		2,985,192,300.0	2,816,337,578.05	94.3%	168,854,721.95
1.1	Санхүүжилтийн орлого	2,303,791,800.0	2,180,719,818.16	94.7%	123,071,981.84
1.2	Дулаан борлуулсны орлого	609,800,500.0	559,835,636.0	92%	49,964,864.0
1.3	Хэрэглээний халуун усны орлого	35,600,000.0	30,921,900.0	86,9%	4,678,100.0
1.4	Бусад орлого	36,000,000.0	44,860,223.89	124.6%	(8,860,223.89)
2. Нийт зардал		3,342,384,400.0	2,877,220,986.68	86%	465,163,413.23
2.1	Цалин, урамшуулал, нэмэгдэл, хоол унааны зардал	1,482,972,600.0	1,458,099,145.41	98.3%	24,873,454.59
2.2	Байгууллагаас төлсөн ЭМ, НДШ зардал	213,936,800.0	196,862,604.63	92%	17,074,195.37
2.3	Цахилгааны төлбөр	192,348,400.0	154,613,968.33	80.4%	37,734,431.67
2.4	Түлш халаалтын зардал	434,174,400.0	309,060,000.0	71.2%	125,114,400.00
2.5	Цэвэр бохир усны төлбөр	75,932,000.0	63,610,350.0	73.8%	12,321,650.00
2.6	Тээврийн зардал	27,237,600.0	23,141,300.0	85%	4,096,300.00
2.7	Шуудан холбооны зардал	2,422,800.0	2,831,608.18	116.9%	(408,808.18)
2.8	Урсгал засвар	93,510,000.0	105,428,720.30	112.7%	(11,918,720.30)
2.9	Шатахууны зардал	46,097,600.0	47,135,515.45	102.2%	(1,037,915.45)
2.10.	Хөдөлмөр хамгаалын зардал	49,471,000.0	34,066,809.11	68.8%	15,404,190.89
2.11	Бичиг хэргийн зардал	3,351,300.0	5,713,823.02	170.5%	(2,362,523.02)
2.12	Нэг удаагийн буцалтгүй тусламж	20,075,500.0	20,683,010.65	103%	607,510.65

2.13	Үндсэн хөрөнгийн элэгдэл	357,192,100.0	360,488,721.64	100.9%	(3,296,621.64)
2.14	Аудитын төлбөр, үйлчилгээний зардал	6,636,100.0	5,000,000.0	85.5%	1.636.100.0
2.15	Газрын төлбөр	2,113,200.0	2,443,879.0	115.6%	(330,679)
2.16	Автомашинны даатгалын зардал	468,000.0	388,786.50	83.1%	79.213.5
2.17	Үл хөдлөх хөрөнгийн татвар	8,954,600.0	9,748,562.23	108.9%	(793,962.23)
2.18	Автотээврийн хэрэгслийн татвар	1,036,500.0	716,034.0	69.1%	320,466.0
2.19	Усны албан татвар	2,391,700.0	4,906,774.25	205.1%	2.515.074.25
2.2	Зам ашигласны төлбөр	1,200,000.0	950,000.0	79.2%	250,000.00
2.21	Агаарын бохирдлын төлбөр	24,300.0	52,800.0	217.2%	(28,500.0)
2.22	Авто тээврийн хэрэгслийн оношилгооны төлбөр	154,000.0	110,000.0	71.4%	44.000.00
2.23	Хог хураамж	1,016,700.0	1,016,700.0	100%	
2.24	Хөрөнгийн зардал	189,764,800.0	-	97.4%	386,090.00
2.25	Нэмэгдсэн өртөгийн албан татвар	129,902,400.0	-	86.1%	3,335,178.00
	Үйл ажиллагааны бус бусад зардал	-	59,325,520.0	-	-
	Воган таталтын зардал	-	3,768,500.0	-	-
	Бусад зардал	-	6,960,000	-	-
	Хүүгийн орлогын албан татвар	-	97,853.98	-	-
	3. Цэвэр ашиг, алдагдал	(357,192,100.0)	(60,883,408.63)	-	-

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6.5 сая төгрөгийн зөрчил¹ илэрсэнд 3 зөвлөмжийг хүргүүлж байна.

Нийт залруулагдаагүй 6,490.1 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшин 27,714.7 мянган төгрөгөөс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Албан шаардлага

Байгууллагуудаас авах авлагаас 3 харилцагчийн 5,324.5 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Эд хариуцагчтай холбоотой асуудал

Илрүүлэлт-2: Эд хариуцагчийн картад хөрөнгийн хөдөлгөөнийг тухай бүр шинэчилж хөтлөөгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйл. 2/ "бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар" гэсэн заалттай нийцээгүй байна санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн хөдөлгөөн гарах бүрд эд хариуцагчийн картад баяжилт хийж байх.

2. Нийгмийн даатгалтай холбоотой асуудал

Илрүүлэлт-3: НДШ-ийн 1,165.6 мянган төгрөгийн илүү төлөлтийг санхүүгийн тайланд тусган тайлагнаагүй. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйл. 2.Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн зарчим 5.1.3.жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4.үнэн зөв байх; гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын тайланг тухайн сар бүр тулгаж баталгаажуулан, төлбөр тооцоог хийж байх.

Дээрх аудитын шийдвэрийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагуудаас авах авлагаас 3 харилцагчийн 5,324,523.77 төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулаагүй байна	1	5,324.5			1	5,324.5		

Багахангай Илч-Орд ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Эд хариуцагчийн картанд хөрөнгийн хөдөлгөөнийг тухай бүр шинэчилж хөтлөөгүйгээс хөрөнгө солигдох эрсдэлтэй байна.	1						1	
НДШ-ийн илүү төлөлтийг 1,165,608.38 төгрөгийг санхүүгийн тайланд тусган тайлагнаагүй.	1	1,165.6					1	1,165.6
Дүн	3	6,490.1			1	5,324.5	2	1,165.6



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 553/1401/0519

Улаанбаатар хот

НИИ-2026/204/НА-СТА-ОНӨУГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багахангай дүүргийн Илч-Орд ОНӨААТҮГ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайланд тусгагдсан авлагаас 5,324,523.77 (таван сая гурван зуун хорин дөрвөн мянга таван зуун хорин гурван төгрөг далан долоон мөнгө) төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, бодитой эсэх нь нотлогдоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулдаггүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх таслан зогсоож, биелэлтийг ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багахангай дүүргийн Илч-Орд ОНӨААТҮГ-ийн гүйцэтгэх захирал (Д.Гантулга), ерөнхий нягтлан бодогч (Ж.Маралгоо) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГЭРЭЛТ ХӨХИЙН ТЭНЦВЭР
АУДИТ ХХК ЗАХИРАЛ



Г.НАНДИНЖАРГАЛ
С.ГАНТӨГС

Д.БААТАРСАЙХАН

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426091015

